



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

“Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин  
тогтоох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь хэсгийг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх бөгөөд компанид засаглалын үнэлгээг хийж, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/-т тус тус үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000063

КОМПАНИД ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ,  
ТҮВШИН ТОГТООХ ЖУРАМ

УХА0410 5043239

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг үргэлжлүүлэн хангуулах, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг дагаж мөрдүүлэх, Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх, засаглалын түвшинг сайжруулах зорилгоор компанид засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, түвшинг тогтоох, түүнийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах, компанийн сайн засаглалын тогтолцоог бий болгоход энэхүү журмыг удирдлага болгоно.

1.2 Компанийн засаглалын үндэсний зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ нь үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 2-т “Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат компанийн засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах механизмыг бий болгох”, 4-т “Компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангуулахад чиглэн ажиллана.

1.3 Мөн зөвлөл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.10-т заасан “Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулахад чиглэн ажиллана.

1.4 Хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон Хөрөнгийн биржийн холбогдох дүрэм, журмын хүрээнд засаглалын үнэлгээг /цаашид “засаглалын үнэлгээ” гэх/ зөвлөл, түүний ажлын албаар үнэлүүлж, түвшинг тогтоолгон хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

1.5 Зөвлөл нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг компаниудын засаглалыг сайжруулах зорилгоор компанид засаглалын үнэлгээг тухайн компанийн удирдлага /Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага/, хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр хийж гүйцэтгэж болно.

1.6 Хувьцаат компани нь засаглалын үнэлгээний тайланг Хорооны 2015 оны 12 дугаарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.3.2.6 дахь заалтын дагуу компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгуулна.

ХОЁР. КОМПАНИД ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙЖ,  
ТҮВШИН ТОГТООХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

2.1 Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

батлуулна;

2.1.2 засаглалын үнэлгээний нэгдсэн аргачлалын дагуу хараат бус, мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ;

2.1.3 засаглалын үнэлгээний тайланг компанийн удирдлагад танилцуулна;

2.1.4 тайланд тусгагдсан асуудлаар засаглалыг сайжруулахад зөвлөмж өгч болно;

2.1.5 засаглалын үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайланд тусгуулж, шаардлагатай бол хувьцаа эзэмшигчдэд мэдээлж болно;

2.1.6 засаглалын үнэлгээг компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн үнэлгээчээр гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно;

2.1.7 энэ журмын 1 дүгээр хавсралтанд тусгасан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох аргачлал”-ын дагуу засаглалын үнэлгээг хийнэ.

## ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ КОМПАНИУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЭРХ ҮҮРЭГ

3.1 Хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй, хувьцаа нь биржээр арилжаалагддаг хувьцаат компаниуд засаглалын үнэлгээг 2 жил тутамд хийлгэж хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.

3.2 Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно. Үүнд:

3.2.1 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани;

3.2.2 арилжааны банк;

3.2.3 даатгалын компани;

3.2.4 хадгаламж зээлийн хоршоо;

3.2.5 аудитын компани;

3.2.6 итгэлцлийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага;

3.2.7 бусад аж ахуйн нэгжүүд.

3.3 Компани нь дараах тохиолдолд засаглалын үнэлгээг хийлгэнэ. Үүнд:

3.3.1 олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн бол уг шийдвэрийг үндэслэн компанийн удирдлагын хүсэлтээр;

3.3.2 хувьцаат компани Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн ангилалд өөрчлөлт оруулах шаардлагын дагуу;

3.3.3 компанид засаглалын түвшинд үүссэн хямралаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр;

3.3.4 бусад.

## ДӨРӨВ. КОМПАНИД ЗАСАГЛАЛЫН ТҮВШИН ТОГТООХ

4.1 Засаглалын үнэлгээний дүнгээс хамаарч дараах байдлаар засаглалын түвшинг тогтооно. Үүнд:

компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн;

4.1.2 засаглалын үнэлгээ 50-74 оноо байвал дунд засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;

4.1.3 засаглалын үнэлгээ 25-49 оноо байвал хангалтгүй засаглалтай буюу компанид хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;

4.1.4 засаглалын үнэлгээ 24 оноогоос доош байвал муу засаглалтай компани буюу компанийн удирдлагын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай.

#### ТАВ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН, ЗАСАГЛАЛЫН ТҮВШИНГ МЭДЭЭЛЭХ

5.1 Хувьцаат компани нь засаглалын үнэлгээний тайланг жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж хувьцаа эзэмшигчдээ мэдээлнэ.

5.2 Хөрөнгийн биржийн хувьцааны бүртгэлийн ангилалд өөрчлөлт оруулахаар засаглалын үнэлгээ хийгдсэн бол зөвлөл нь уг үнэлгээний тайланг Хөрөнгийн биржид хүргүүлнэ.

5.3 Компани нь засаглалын үнэлгээний түвшинг Хөрөнгийн биржийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэж болно.

5.4 Засаглалын үнэлгээний тайланг компанийн зөвшөөрлөөр Хороо болон зөвлөлийн цахим хуудсаар нийтэд мэдээлж болно.

-----oOo-----



**КОМПАНИД ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ  
АРГАЧЛАЛ**

УХА0410 5043239

**НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР**

Компанид засаглалын үнэлгээг хийж, түвшин тогтоохын тулд тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх хамгаалагдсан байдал, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр өгөөж, гүйцэтгэх удирдлагын менежментийн чадвар, компанийн нээлттэй байдал болон нийгмийн хариуцлага, компанийн оролцогч талуудтай харилцах харилцаа зэргийг үнэлнэ.

Засаглалын үнэлгээг хийхдээ Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийг гол шалгуур болгох ба зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн /Итгэлцэлтэй банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаас гаргагч/ нарийвчилсан эрх зүйн хэм хэмжээг шалгуур болгоно.

Компанийн засаглалын үнэлгээ дараах хэсэгтэй байна. Үүнд:

**1. Хувьцаа эзэмшигчдийн эрх**

Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхүүд хангагдсан эсэх, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуулийн дагуу явагддаг эсэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн хамгаалалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын журам, ногдол ашгийн бодлоготой эсэх зэрэг асуудлын хүрээнд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын хүрээнд үнэлнэ.

**2. Нээлттэй ил тод байдал**

Компани жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэдэг эсэх, цахим хуудастай эсэх, жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудас нь Хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хүрээнд мэдээллийг бүрэн агуулдаг эсэх, компани хөрөнгө оруулагч, харилцагч байгууллага зэрэг оролцогч талуудад нээлттэй ил тод байдлыг хангасан байдал, компани мэдээллийн журамтай эсэхийг үнэлнэ.

**3. ТУЗ -ын хүлээх үүрэг хариуцлага**

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц хуульд нийцэж байгаа эсэх, ТУЗ хороодтой эсэх, хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай эсэх зэрэг нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексд нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

**4. Гүйцэтгэх удирдлага**

Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан журам, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ хуульд нийцэж байгаа эсэх, Гүйцэтгэх удирдлагын ёс зүйн дүрэм зэрэг асуудлууд Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексд нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

## 5. Оролцогч талууд

Компани өөрийн харилцагчид болох бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, ажиллагсад, харилцагч банк, өрсөлдөгч, хөрөнгө оруулагч, төрийн байгууллага зэрэг этгээдүүтэй харилцах бодлого журамтай эсэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх байдал, нийгмийн хариуцлага хэрэгжүүлдэг эсэх зэрэг оролцогч талуудтай холбоотой харилцааг үнэлнэ.

### **ХОЁР. ҮЕ ШАТ**

Компанийн засаглалын үнэлгээг дараах 3 үе шаттайгаар хийнэ.

#### 1 дүгээр үе шат

Баримт бичгийн шалгалт: Энэ шатанд компанийн засаглалын үнэлгээ хийлгэж буй компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас батлан гаргасан тухайн компанийн дотоодод мөрдөгддөг засаглалтай холбоотой эрх зүйн хэм хэмжээний актууд нь агуулгаараа Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

#### 2 дугаар үе шат

Хэрэгжилтийг шалгах: Энэ шатанд баримт бичигт тусгагдсан хэм хэмжээнүүд бодит байдал дээр компанийн үйл ажиллагаанд хэрэгждэг эсэхийг шалгана. Мөн компани дотоод дүрэм журамдаа тусгасан боловч үйл ажиллагаандаа хэвшүүлсэн эсэхийг давхар шалгана.

#### 3 дугаар үе шат

Үнэлгээ ба тайлагнал: Энэ шатанд засаглалын үнэлгээний 1 ба 2 дугаар шатанд нягталсан тухай компанийн нотлох баримт бичигт үндэслэн асуулга тус бүрт зохих үнэлгээний оноог өгч, нэгдсэн засаглалын үнэлгээний тайланг гаргана.

### **ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

Компанийн засаглалын үнэлгээний асуулга тус бүрийг үнэлгээ хийлгэж буй компани ямар түвшинд хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан компанийн засаглалын үнэлгээг тоон үзүүлэлтээр үнэлнэ. Үнэлгээг дараах таван түвшингээр үнэлнэ. Үүнд:

“4” оноо буюу бүрэн хэрэгжүүлдэг: Энэ оноог тус үзүүлэлтийг компани бүрэн мөрдөж байгаа нөхцөлд өгөх бөгөөд компанийн сайн засаглалын туршлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд өгнө.

“3” оноо буюу хэрэгжүүлдэг: Энэ оноог тус үзүүлэлтийг компани мөрдөж байгаа нөхцөлд өгөх бөгөөд компанийн засаглалын туршлагыг боломжийн түвшинд хэрэгжүүлж байгаа тохиолдолд өгнө.

“2” оноо буюу хагас хэрэгжүүлдэг: Энэ оноог тус үзүүлэлтийг компани хагас дутуу хэрэгжүүлдэг, мөн зөвхөн баримт бичгийн түвшинд хэрэгжүүлээд практик хэрэглээ хангалтгүй байгаа тохиолдолд өгнө.

“0” оноо буюу зарим хэсгийн хэрэгжүүлдэг. Энэ оноог тус үзүүлэлтийн компани зарим хэсгийг хэрэгжүүлдэг хангалтгүй байгаа нөхцөлд өгнө.

“0” оноо буюу хэрэгжүүлдэггүй: Энэ оноог тус үзүүлэлтийг компанид огт хэрэгжүүлдэггүй нөхцөлд өгнө.

-----oOo-----